



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

БАЯНХОНГОР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТ ХИЙСЭН: Аудитыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн захиалга, аймгийн Аудитын газрын 2015 оны аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: Баянхонгор аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүн.

АУДИТЫН ДҮГНЭЛТ: “Ажлын гараа”, “Сумын залуус” хөтөлбөрүүд Баянхонгор аймгийн 20 суманд хэрэгжиж 504 оюутан, залуусыг ажлын түр байраар ханган 29 жишиг өвөлжөө, хороог шинээр барьж, 135 тн хадлан тэжээл бэлтгэн, хуучин хашаа хороо, худаг, гудамжийг сэргээн засварлах, байгаль эхээ цэвэр ариун байлгах зорилгоор хурсан хогийг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сумын ард иргэдэд эрүүл зөв хооллолт, англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт, спортын арга хэмжээнүүд зохион байгуулсан байна

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

*Үндэсний Аудитын газрын харьяа
Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор*

Ё. Сугаррагчаа

Аудитын менежер

А.Оюуяа

Аудитор

М.Алтантуяа

Шинжээч

Б.Цэрэнчимэд

2015 оны 7 дүгээр сарын 05

Тайланг Аймгийн аудитын газрын Цахим хуудаснаас

үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442584, 70442424 дугаарын утсаар харилцана уу.

ХАЯГ: Үндэсний аудитын газрын харьяа

Аймгийн Аудитын газар

Товчилсон үгийн жагсаалт.....	0
АУДИТЫН ТАЙЛАН	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур, үзүүлэлт, аудит хийх үндэслэл.....	3
АУДИТЫН ДҮН	5
Зорилт-1: Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн шийдвэрээр “Ажлын гараа”, “Сумын залуус” төслийн хаалт, залуучуудын зөвлөгөөн, чуулга уулзалт зохион байгуулж, дээрхи хөтөлбөрийн санхүүжилтээс 8400,0 мянган төгрөг зарцуулсан нь “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн 4.1, 4.2-д “... төсөлд хамрагдан ажлын 21 өдрөөс доошгүй хоног ажилласан оюутан, залуучуудад 200,0 мянган төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.	5
Зорилт-2: “Ажлын гараа”, “Сумын залуус” хөтөлбөрүүд Баянхонгор аймгийн 20 суманд хэрэгжиж 504 оюутан, залуусыг ажлын түр байраар ханган 29 жишиг өвөлжөө, хороог шинээр барьж, 135 тн хадлан тэжээл бэлтгэн, хуучин хашаа хороо, худаг, гудамжийг сэргээн засварлах, байгаль эхээ цэвэр ариун байлгах зорилгоор хурсан хогийг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сумын ард иргэдэд эрүүл зөв хооллолт, англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт, спортын арга хэмжээнүүд зохион байгуулсан байна.....	7
АУДИТЫН ДҮГНЭЛТ	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур, үзүүлэлт, аудит хийх үндэслэл

1.Аудитын нэр

Баянхонгор аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүн.

2.Аудитын код: БХГ-ГАГ/2015/02-ГА

3.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн захиалга, аймгийн Аудитын газрын 2015 оны аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

4.Аудитын зорилт

Аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт.
- Хөтөлбөрийг орон нутагт зохион байгуулсан байдал түүний хэрэгжилт, үр дүн.

5.Аудитын хамрах хүрээ

2014 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т олгосон хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

6. Үндсэн мэдээлэл: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 28.8.2-т заасныг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014.01.13-ны өдрийн 05 тоот тогтоолын 7 дугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг баталжээ.

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд 2014 онд Залуучуудын хөдөлмөр

зарцуулсан. Үүнээс “Сумын залуус” төсөлд 54 иргэн хамрагдаж 10,8 сая, “Ажлын гараа” төсөлд 730 хүн хамрагдаж 90,0 сая, залуучуудийн зөвлөгөөний зардалд 8,4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ. *(Эрсдэлийн үнэлгээг хөвсрэлт № 1-ээс үзнэ үү.)*

8.Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг баримтлан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага, асуулга хийх, судалгаа гаргуулах, дүн шинжилгээ хийх аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

9.Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль. эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
- Холбогдох тогтоол шийдвэр

10.Аудит хийх бүрэлдэхүүн.

Аудитыг Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ё.Сугаррагчаа удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж аудитор М.Алтантуяа, шинжээч Б.Цэрэнчимэд нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн захиалгаар Баянхонгор аймгийн хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Зорилт-1: Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн шийдвэрээр “Ажлын гараа”, “Сумын залуус” төслийн хаалт, залуучуудын зөвлөгөөн, чуулга уулзалт зохион байгуулж, дээрхи хөтөлбөрийн санхүүжилтээс 8400,0 мянган төгрөг зарцуулсан нь “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн 4.1, 4.2-д “... төсөлд хамрагдан ажлын 21 өдрөөс доошгүй хоног ажилласан оюутан, залуучуудад 200,0 мянган төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014.01.13-ны өдрийн 05 тоот тогтоолоор “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд тус хөтөлбөрийн хүрээнд “Сумын залуус”, “Ажлын гараа” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хөтөлбөрт хамрагдсан оюутан залуусыг баг болгон ажлын 21 хоногийн турш үйл ажиллагаагаа явуулж урамшуулалд нэг иргэнд 200,0 мянган төгрөгийн урамшуулал олгохоор тусгажээ.

Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төвийн 2014 оны 6-р сарын 12-нд 2/1192 тоот албан бичгээр “Сумын залуус” төслийн хүрээнд нэг суманд 4 оюутан 10 модуль хөтөлбөрөөс сонгон хэрэгжүүлэх, “Ажлын гараа” төслийн хүрээнд нэг суманд ажил хөдөлмөр эрхлээгүй 23 залуучуу нэг баг болгон сум бүрт жишиг өвөлжөө, нэг аймагт 7 жишиг гудамж, талбай, цэцэрлэгт хүрээлэн, 5 худаг, зам гүүр болон хадлан тэжээл бэлтгэх ажилд 21-ээс доошгүй хоног ажиллуулж, нэг хүнд 200,0 мянган төгрөгийн урамшуулал олгох зөвлөмжийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэст ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2014.04.17-ны өдрийн №05 тогтоолоор Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн төсөв, төлөвлөгөөг аймгийн 21 суманд жишиг өвөлжөө барих, худаг гаргах, наадмын талбай засах зэрэг ажлуудад 76,0 сая төгрөг, 2014.05.28-ны өдрийн №09 тоот тогтоолоор “Ажлын гараа” төслийн хэрэгжилтэд зориулж 54,0 сая төгрөгийн төсвийг зарцуулахыг, 2014.09.10-ны өдрийн тогтоолоор нийгмийн идэвхи санаачилга гаргаж үр дүнтэй ажилласан сум, орон нутаг,

залуучуудын багийг шалгаруулж урамшуулах ба үүнд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хуваарилсан нийт хөрөнгийн 10 хүртэл хувь байхаар тооцож, үүнээс “Ажлын гараа” төслийн хаалтанд зориулж аймгийн залуучуудийн зөвлөгөөн зохион байгуулахыг тус тус баталсан байна..

Хөдөлмөрийн яамны 2014.08.28-ны өдрийн 5а/1972 тоот тогтоолоор Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2014 оны төсвийг шинэчлэн “Сумын залуус” хөтөлбөрт 45,0 сая төгрөг, “Ажлын гараа” хөтөлбөрт 75,0 сая төгрөг нийт 120,0 сая төгрөг баталсан ба гүйцэтгэлээр 109,2 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

“Ажлын гараа” төсөлд Баянхонгор аймгийн 20 сумын 448 оюутан, залуус хамрагдаж урамшуулалд 89,6 сая төгрөг, “Сумын залуус” төсөлд 14 сумын 56 оюутан залуус оролцон урамшуулалд 11,2 сая төгрөг, аймгийн төвд залуучуудын нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулсны зардалд 8,4 сая төгрөг, нийт 109,2 сая төгрөг зарцуулжээ.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон хөрөнгийг урамшуулалд зарцуулахдаа “Ажлын гараа” болон “Сумын залуу” хөтөлбөрт хамрагдсан оюутан залуусын хийсэн ажлын тайлан /фото зургаар баталгаажсан/, сумын Засаг даргын тодорхойлолт болон холбогдох бичиг баримтуудыг үндэслэн олгожээ.

Ажлын гараа төслөөр зарим сумдад цөөн хүмүүс ажиллуулсан, “Сумын залуус” төслийг 6 суманд хэрэгжүүлээгүй зэргээс 8400,0 мянган төгрөгийн санхүүжилт үлдсэнийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн шийдвэрээр “Ажлын гараа”, “Сумын залуус” төслийн хаалт, залуучуудын чуулга уулзалт зохион байгуулж, зарцуулсан нь “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн 4.1, 4.2-д “... төсөлд хамрагдан ажлын 21 өдрөөс доошгүй хоног ажилласан оюутан, залуучуудад 200,0 мянган төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно” гэсэнтэй нийцэхгүй байна. Энэ нь хөтөлбөрийн хүрээнд оюутан залуучууд, ажил хөдөлмөр эрхлээгүй залуусын хүчийг бүрэн ашиглаж, хөдөө орон нутагт харьцангуй бага зардлаар малчдын жишиг өвөлжөө, хаваржаа барьж, худаг ус гаргах, хадлан тэжээл бэлтгэх боломжийг бүрэн ашиглаж чадаагүй байна.


Мөн “Ажлын гараа” төслийн хүрээнд Баянхонгор сумын ахмадын цэцэрлэгт хүрээлэнд ажилласан 15 иргэний урамшуулалд 2014 оны 10-р сарын 28-ний өдөр 3000,0 мянган төгрөгийг Төгс төгөлдөр үйлс ХХК-д шилжүүлснийг тус компанийн нягтлан бодогч Р.Тогтохоос тодруулахад 4 иргэн нь Төгс төгөлдөр үйлс ХХК-ийн үндсэн

ажилтан болох нь цалингийн цэс, нийгмийн даатгалын мэдээгээр нотлогдож байна. Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2014.01.13-ны өдрийн 05 тоот тогтоолын 7 дугаар хавсралтаар “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн 2.2 -д “Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгэлтэй, сумын ажилгүй залуучуудын баг байна” гэснийг зөрчиж байгаа тул 800,0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Зорилт-2: “Ажлын гараа”, “Сумын залуус” хөтөлбөрүүд Баянхонгор аймгийн 20 суманд хэрэгжиж 504 оюутан, залуусыг ажлын түр байраар ханган 29 жишиг өвөлжөө, хороог шинээр барьж, 135 тн хадлан тэжээл бэлтгэн, хуучин хашаа хороо, худаг, гудамжийг сэргээн засварлах, байгаль эхээ цэвэр ариун байлгах зорилгоор хурсан хогийг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сумын ард иргэдэд эрүүл зөв хооллолт, англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт, спортын арга хэмжээнүүд зохион байгуулсан байна.

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанд “Ажлын гараа” хөтөлбөрийн хүрээнд 20 сумаас өвөлжөө хаваржаа барих, хадлан тэжээл бэлтгэх, худаг сэргээн засварлах зэрэг 56 захиалга ирүүлснээс 16 захиалагчийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба хөтөлбөр хэрэгжих хугацаанд шинээр 40 иргэн өвөлжөө, хаваржаа засах, хадлан тэжээл бэлтгэх ажлын захиалга өгчээ. “Ажлын гараа” хөтөлбөрийн захиалгын дагуу 20 суманд 448 оюутан, залуус 2014.07.01-2014.08.30 –ны хооронд 15-30 залуусын бүрэлдэхүүнтэй баг болон ажиллажээ.

Тус хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 96 нь Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгэлтэй, 373 нь 35 хүртэлх насны залуучууд байна.




“Ажлын гараа” хөтөлбөр хэрэгжсэнээр:

- 29 жишиг өвөлжөө, төл болон хээлтүүлэгч малын хороо шинээр барьсан,
- Хуучин малын хороог буулган сэргээн засварласан 6,

- 135 тн хадлан бэлтгэсэн,
- 3 худгийг сэргээн засварласан,
- Жишиг гудамж, цэцэрлэгт хүрээлэн тохижуулах-3,
- Баацагаан сумын Бөөн цагаан нуурын эргийн хогийг цэвэрлэсэн
- Богд суманд гүүрний далан болон үерийн хамгаалалтын даланг барьсан

Эрдэнэцогт суманд Шар хөтөлийн давааг зассан зэрэг ажлууд хийж гүйцэтгэн, хүлээлгэн өгсөнөөс гадна 448 түр ажлын байр бий болж, иргэдийн орлого 89,6 сая төгрөгөөр нэмэгджээ.

“Сумын залуус” хөтөлбөр Жинст, Баянлиг, Богд, Эрдэнэцогт, Баян-Өндөр сумаас бусад суманд амжилттай хэрэгжсэн бөгөөд “Сумын залуус” хөтөлбөрт хамрагдах 56 оюутныг Залуучуудын хөдөлмөрийн төв бирж дээр бүртгэн, сургалт явуулж арга зүйн зөвлөгөөгөөр хангасан байна.



Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв, Залуучуудын хөдөлмөрийн төв биржийн захирал нарын хамтарсан “Сумын залуус” төслийн “Дөрвөн бэрх” багийн ажиллах удирдамжийн дагуу сум бүрт боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний 13 модулиас 4-8 нь хэрэгжсэн байна.

“Сумын залуус” хөтөлбөрт хамрагдсан оюутнууд 2014 оны 7-р сарын 01-наас 8-р сарын 30-ны хооронд өөр өөрийн хариуцсан сумын ард иргэд болон залуучуудын дунд эрүүл зөв хооллолт, “спирт үү, спорт уу” сэдэвт спортын арга хэмжээг зохион байгуулан, оюутан залуучуудын чуулга уулзалтыг 6 сум зохион байгуулсан байна.

Хөтөлбөрийн явцад хийгдсэн ажлуудаас онцолбол:

- **Баацагаан сум:** Сумын иргэдэд эмнэлгийн анхан шатны тусламжийг хэрхэн хүргэх талаар үзүүлэх сургалт зохион байгуулсан
- **Баянбулаг сум:** Бүрд булаг болон Хөдөө нуурын хогыг цэвэрлэсэн, эрүүл зөв хооллолтын сургалтын үеэр эрүүл хоол хийх талаар хичээл зааж, хоолны үзэсгэлэн гаргасан
- **Баянговь сум:** Тус сумын 4 багийн иргэн С.Очбадрахын эмчилгээний зардалд хандив цуглуулж сайн дурын ажилд залуучуудыг манлайлан оролцсон
- **Баянцагаан сум:** ЖДҮ -ын төсөл бичих аргачлал боловсруулан сумын иргэдэд сургалт явуулсан бөгөөд зүү ороох оёдлыг 7 иргэнд зааж сургасан
- **Бөмбөгөр сум:** Үндэсний бахархал сэдэвт монгол дээл, жороо морь, адуучин тэмцээн зохион байгуулсан
- **Бууцагаан сум:** Багуудын өдөрлөг хийж хөгжөөнт тэмцээн зохион байгуулсан
- **Галуут сум:** Хэрэгжүүлэх ажил бүрээр удирдамж гарган батлуулж ажил хэрэгч хандсан
- **Гурванбулаг сум:** "Орчин үеийн боловсролыг малны хотонд" сургалтыг малчин өрхүүдын хотонд нь зохион байгуулж. Өндөр настан ганц бие Д.Жавзандулам эмээд тусалсан
- **Жаргалант сум:** “Би авилга авахгүй, өгөхгүй” амлалтын бичгийг төрийн албан хаагчдаар бичүүлж бүх албан газрын хаалган дээр наан байршуулсан.
- **Заг сум:** “Гэр бүлийн хүчирхийлэл” сэдвээр илтгэл тавьж, шинээр гэр бүл болсон Н.Наранхүүд гитар хөгжим зааж бэлэглэлээ. Халуус усны барилгын ажилд сайн дураараа 5 хоног ажиллалаа.
- **Өлзийт сум:** Сумын ЕБС-ын дотуур байранд номын сан байгуулж сургуульд хүлээлгэн өгсөн
- **Хүрээмарал сум:** Модуль бүрээр зорилт тавин сэдэвчилсэн төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулсан
- **Шинэжинст сум:** Залуучуудын чуулга уулзалтын үеэр сумын удирдлагуудтай уулзан залуучуудын чөлөөт цагаа зөв өнгөрөөх спорт зал байхгүй, соёлын төвийн үйл ажиллагаа зогсонги зэрэг тулгамдсан асуудлаар хэлэлцүүлэг хийсэн.

“Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, үр дүнг олон нийтэд сурталчилах, туршлага солилцох зорилгоор аймгийн

Хөдөлмөрийн хэлтэс, Залуучуудын холбоо хамтран 2014 оны 9-р сарын 18, 19 –ны өдрүүдэд “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, тулгамдаж буй асуудал” сэдвээр чуулга уулзалт зохион байгуулж дээрх хөтөлбөрийн үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна.

Чуулга уулзалтад УИХ-ийн гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Ганбат, аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэн, аймгийн Засаг дарга Д.Жаргалсайхан, Хөдөлмөрийн хэлтсийн дарга С.Баярмагнай, Залуучуудын хөдөлмөрийн төв биржийн захирал Б.Эрдэнэбат нар болон сум, орон нутгийн 300 оюутан, залуус оролцжээ.

Аудитаар 9200,0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 800,0 мянган төгрөгийг “Төгс төгөлдөр үйлс” ХХК-иар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож 8400,0 мянган төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байхыг зөвлөв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

1. “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-г Баянхонгор аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн 2014.04.17-ны өдрийн №05 тогтоолоор 76,0 сая төгрөг, 2014.05.28-ны өдрийн №09 тоот тогтоолоор 54,0 сая төгрөгийг зарцуулахыг, 2014.09.10-ын өдрийн №11 тоот тогтоолоор нийгмийн идэвхи санаачилга гаргаж үр дүнтэй ажилласан сум, орон нутаг, залуучуудын багийг тус тус шалгаруулж урамшуулах ба үүнд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хуваарилсан нийт хөрөнгийн 10 хүртэл хувь байхаар тооцож, үүнээс “Ажлын гараа” төслийн хаалтанд зориулж аймгийн залуучуудийн зөвлөгөөн зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна.
2. “Сумын залуус” хөтөлбөрт 45,0 сая төгрөг, “Ажлын гараа” хөтөлбөрт 75,0 сая төгрөг нийт 120,0 сая төгрөг баталсан ба оюутан, залуучуудын багийн хийсэн ажлын гүйцэтгэлээр “Ажлын гараа” хөтөлбөрийн урамшуулалд 89,6 сая, “Сумын залуус” хөтөлбөрийн урамшуулалд 11,2 сая, аймгийн төвд залуучуудын нэгдсэн зөвлөгөөний зардалд 8,4 сая, нийт 109,2 сая төгрөг зарцуулжээ.
3. Аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбар зөвлөлийн шийдвэрээр “Ажлын гараа”, “Сумын залуус” төслийн хаалт, залуучуудын чуулга уулзалт зохион байгуулж, дээрхи хөтөлбөрийн санхүүжилтээс 8400,0 мянган төгрөг зарцуулсан нь “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийн 4.1, 4.2-д “... төсөлд хамрагдан ажлын 21 өдрөөс доошгүй хоног ажилласан оюутан, залуучуудад 200,0 мянган төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно” гэсэн заалтыг зөрчсөн.
4. Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн албанд “Ажлын гараа” хөтөлбөрийн хүрээнд 20 сумаас өвөлжөө хаваржаа барих, хадлан тэжээл бэлтгэх, худаг сэргээн засварлах зэрэг 56 захиалга ирүүлснээс 16 захиалагчийн ажлыг, хөтөлбөр хэрэгжих хугацаанд шинээр 40 иргэний захиалгын дагуу залуучуудын баг өвөлжөө, хаваржаа засах, хадлан тэжээл бэлтгэх ажлуудыг гүйцэтгэжээ.
5. “Ажлын гараа” хөтөлбөрт хамрагдсан иргэдийн 96 нь Хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санд бүртгэлтэй, 373 нь 35 хүртэлх насны залуучууд, “Сумын залуус” хөтөлбөрт хамрагдсан 56 оюутнууд Залуучуудын хөдөлмөрийн төв биржийн мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

6. “Ажлын гараа”, “Сумын залуус” хөтөлбөрүүд Баянхонгор аймгийн 20 суманд хэрэгжиж 504 оюутан, залуусыг ажлын түр байраар ханган 29 жишиг өвөлжөө, хороог шинээр барьж, 135 тн хадлан тэжээл бэлтгэн, хуучин хашаа хороо, худаг, гудамжийг сэргээн засварлах, байгаль эхээ цэвэр ариун байлгах зорилгоор хурсан хогийг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сумын ард иргэдэд эрүүл зөв хооллолт, англи хэлний анхан шатны мэдлэг олгох сургалт, спортын арга хэмжээнүүд зохион байгуулсан байна.

Гүйцэтгэлийн аудитаар тогтоосон актыг хугацаанд нь биелүүлж 2015 оны 9 дүгээр сарын 10-ны дотор аймгийн Аудитын газарт хариу ирүүлэхийг мэдэгдье.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ё.СУГАРРАГЧАА